



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/301

Булган сум

Гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XI.1.1.13, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10, 35 дүгээр зүйлийн 35.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XI.1.1.13, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.2.4, Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлийн 1.1.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлийн 1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 03-ний өдрийн II/04 дугаар хуралдааны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр батлах тухай тогтоолын хавсралтын 1.6.2.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн А/590 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Булган аймгийн “Жаргалант” хүүхдийн зуслангийн өргөтгөлийн “Жаргалант хотхон” /60 ор/-той барилгын гадна инженерийн шугам сүлжээ /цахилгаан, цэвэр ус, бохир ус, цэвэрлэх байгууламж, усан сангийн насосны станц/-ний зураг төслийг боловсруулан, магадлалд хамруулан хүлээлгэн өгөхөд “Эрч булаг ллайн” ХХК-тай 54,153,500 (тавин дөрвөн сая нэг зуун тавин гурван мянга таван зуу) төгрөг, төсөв шинэчлэн магадлалд хамруулан хүлээлгэн өгөхөд “Нарлаг хөхий” ХХК-тай 8,000,000 (найман сая) төгрөгөөр тус тус шууд гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Дээрх зураг төсвийг гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгэн, магадлалд хамруулан хүлээлгэн өгөхийг “Эрч булаг ллайн” ХХК-ын захирал (Э.Янжинлхам), “Нарлаг хөхий” ХХК ын захирал (Б.Мөнхбат)-д тус тус үүрэг болгосугай.

3.Гэрээнд заагдсан “Эрч булаг ллайн” ХХК 50,153,500 (тавин сая нэг зуун тавин гурван мянга таван зуу), “Нарлаг хөхий” ХХК-тай 8,000,000 (найман сая) төгрөгийн

санхүүжилтийг Улсын төсвийн батлагдсан хөрөнгө оруулалтаас гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Т.Баярбат)-т даалгасугай, “Эрч булаг лайн” ХХК 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж, хүлээн авч, холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

